



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/449

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны  
“Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төвийн  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,216,398 (таван сая хоёр зуун арван зургаан мянга гурван зуун ерэн найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төв (Ч.Цэрэндолгор)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 11 нэр төрлийн 4,296,498 (дөрвөн сая хоёр зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун ерэн найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 4 нэр төрлийн 919,900 (есөн зуун арван есөн мянга есөн зуу) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 15,000 (арван таван мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төв (Ч.Цэрэндолгор)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001227



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/419 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны "Дотны туслагч" ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж												
1	Угаалгын машин	13	ш	1	130,000	130,000	130,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
2	Хөргөгч	21	ш	1	499,103	499,103	499,103.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
3	Гүйлтийн зам	12	ш	1	315,000	315,000	315,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	20,000	20,000
4	Жийдэг унадаг дугуй	12	ш	1	268,000	268,000	268,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
5	Пульсоксометр	11	ш	1	147,560	147,560	147,560.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
6	Автоклав	8	ш	1	299,900	299,900	299,900.00	-	Ашиглах боломжгүй	актлах	15,000	15,000
7	Автомас	7	ш	1	35,000	35,000	30,624.72	4,375.28	Ашиглах боломжгүй	актлах	5,000	5,000
8	Жин өндөр хэмжигч	12	ш	1	110,000	110,000	110,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
9	Агаар ариутгагч	8	ш	1	270,000	270,000	270,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	10,000	10,000
10	Жин өндөр хэмжигч	8	ш	1	103,299	103,299	101,577.94	1,721.06	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
Машин, тоног төхөөрөмжийн дүн						<b>2,177,862.00</b>	<b>2,171,765.66</b>	<b>6,096.34</b>				<b>50,000</b>
Тавилга, эд хогшил												
1	Бичгийн ширээ	20	ш	4	318,384	1,273,536.00	1,273,536.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах



2	Ширээ	11	ш	1	260,000	260,000.00	260,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
3	Эмэгтэйчүүдийн үзлэгийн ор	8	ш	1	651,000	651,000.00	651,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
4	Эмийн шүүгээ	10	ш	1	320,000	320,000.00	320,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
5	Түшлэгтэй сандал	9	ш	6	89,000	534,000.00	498,400.10	35,599.90	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
	Тавилга, эд хогшлын дүн					<b>3,038,536.00</b>	<b>3,002,936.10</b>	<b>35,599.90</b>				-
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					<b>5,216,398.00</b>	<b>5,174,701.76</b>	<b>41,696.24</b>				<b>50,000</b>
	Үүнээс: Худалдах хөрөнгө					919,900.00	915,524.72	4,375.28				
	Татан төвлөрүүлэх хөрөнгө					-	-	-				
	Устгах хөрөнгө					4,296,498.00	4,259,177.04	37,320.96				
	Худалдсанаас олох орлого					50,000						
	НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/					15,000						